

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Агуулга

Агуулга	2
1. Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	10
3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.9. Аудитын илрүүлэлт	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын залруулга болон албан шаардлага.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ
ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ
ШИНЭЭР БАРИХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Т.БОЛОРЧУЛУУН
ТАНАА

2021.02.25 № 07/568
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгжийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгжийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,257,192.00	209,825,846,829.51
33	АВЛАГА	-	117,180.71
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	117,180.71
34	УРЬДЧИЛГАА	-	209,775,199,515.80
34600	Урьдчилж гарсан зардал	-	209,775,199,515.80
35	БАРАА МАТЕРИАЛ	35,257,192.00	50,530,133.00
354	Хангамжийн материал	35,257,192.00	50,530,133.00
35410	Бичиг хэргийн материал	1,751,600.00	1,448,000.00
35440	Шатах тослох материал	5,115,225.00	12,940,316.00
35470	Бусад хангамжийн материал	28,390,367.00	36,141,817.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	175,418,342.99	392,634,057.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	175,418,342.99	392,634,057.23
392	Биет хөрөнгө	173,738,476.32	391,298,990.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	250,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж	104,568,300.00	114,518,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,627,826.68)	(38,860,503.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,518,090.00	74,518,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,720,087.00)	(9,576,896.08)
393	Биет бус хөрөнгө	1,679,866.67	1,335,066.71
39301	Программ хангамж	1,724,000.00	1,724,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(44,133.33)	(388,933.29)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	210,675,534.99	210,218,480,886.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	210,675,534.99	210,218,480,886.74
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	210,675,534.99	210,218,480,886.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-	210,675,534.99
51220	Тайлант үеийн үр дүн	210,675,534.99	210,007,805,351.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	210,675,534.99	210,218,480,886.74

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	992,902,700.00	211,168,810,115.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	210,026,349,515.80
120	Нийтлэг татварын бус орлого	-	210,025,999,515.80
120004	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-	209,775,199,515.80
1200045	Дотоод эх үүсвэрээс санхүүжих	-	250,800,000.00
120009	Бусад орлого	-	350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	992,902,700.00	1,142,460,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	992,902,700.00	1,142,460,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	992,902,700.00	1,142,460,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	782,227,165.01	1,161,004,764.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	782,227,165.01	1,161,004,764.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	287,636,731.34	1,004,165,583.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	523,158,976.93
210101	Үндсэн цалин	-	523,158,976.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,227,049.23	89,662,256.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,806,000.00	69,210,000.00
210304	Байрны түрээс	33,806,000.00	69,210,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,192,863.00	27,579,068.02
210401	Бичиг хэрэг	2,547,285.00	7,595,850.00
210402	Тээвэр, шатахуун	1,056,375.00	5,526,409.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,173,730.00	5,109,959.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,415,473.00	9,346,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	837,050.00	-
210604	Урсгал засвар	837,050.00	-
2107	Томилолт, зочны зардал	17,949,488.80	3,258,288.00
210701	Гадаад албан томилолт	2,649,488.80	-
210702	Дотоод албан томилолт	15,300,000.00	3,258,288.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	194,232,233.30	247,862,707.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,232,233.30	247,719,607.87
210803	Даатгалын үйлчилгээ	-	143,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,392,047.01	43,434,285.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,392,047.01	43,434,285.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	494,590,433.67	156,839,180.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	494,590,433.67	156,839,180.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	210,675,534.99	210,007,805,351.75
5	НИЙТ ҮР ДҮН	210,675,534.99	210,007,805,351.75

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	992,902,700.00	1,143,360,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	900,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	900,000.00
120009	Бусад орлого	-	900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	992,902,700.00	1,142,460,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	992,902,700.00	1,142,460,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	992,902,700.00	1,142,460,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	812,092,310.00	1,133,510,590.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,501,876.33	976,671,409.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,501,876.33	976,671,409.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	533,368,326.81
210101	Үндсэн цалин	-	533,368,326.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,163,927.13	93,668,781.00
210201	Тэтгэврийн даатгал	41,163,927.13	93,668,781.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,806,000.00	69,210,000.00
210304	Байрны түрээс	33,806,000.00	69,210,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,464,480.00	30,667,559.02
210401	Бичиг хэрэг	3,876,785.00	6,794,250.00
210402	Тээвэр, шатахуун	6,171,600.00	13,351,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,173,730.00	5,109,959.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,242,365.00	5,411,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,796,550.00	-
210601	Багаж техник хэрэгсэл	199,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	23,760,000.00	-
210604	Урсгал засвар	837,050.00	-
2107	Томилолт, зочны зардал	17,949,488.80	3,258,288.00
210701	Гадаад албан томилолт	2,649,488.80	-
210702	Дотоод албан томилолт	15,300,000.00	3,258,288.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	194,232,233.30	247,862,707.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,232,233.30	247,719,607.87
210803	Даатгалын үйлчилгээ	-	143,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	494,590,433.67	156,839,180.64
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	494,590,433.67	156,839,180.64
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	494,590,433.67	156,839,180.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	180,810,390.00	9,850,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	180,810,390.00	9,850,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	180,810,390.00	9,850,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	180,810,390.00	9,850,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	180,810,390.00	9,850,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(180,810,390.00)	(9,850,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			210,675,534.99	210,675,534.99
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			210,675,534.99	210,675,534.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	210,675,534.99	210,675,534.99
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	210,007,805,351.75	210,007,805,351.75
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	210,218,480,886.74	210,218,480,886.74

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	210,917,660,200.00	210,761,720,935.16	155,939,264.84	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,142,460,600.00	986,521,419.36	155,939,180.64	86.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,142,460,600.00	986,521,419.36	155,939,180.64	86.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	533,381,000.00	533,368,326.81	12,673.19	100.0
Үндсэн цалин	533,381,000.00	533,368,326.81	12,673.19	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,060,000.00	93,668,781.00	3,391,219.00	96.5
Тэтгэврийн даатгал	97,060,000.00	93,668,781.00	3,391,219.00	96.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,210,000.00	69,210,000.00	-	100.0
Байрны түрээс	69,210,000.00	69,210,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	30,707,000.00	30,667,559.02	39,440.98	99.9
Бичиг хэрэг	6,800,000.00	6,794,250.00	5,750.00	99.9
Тээвэр, шатахуун	13,371,500.00	13,351,500.00	20,000.00	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,110,000.00	5,109,959.02	40.98	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,425,500.00	5,411,850.00	13,650.00	99.7
Эд хогшил, урсгал засварын зардал	27,450,100.00	9,850,000.00	17,600,100.00	35.9

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгжийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Урсгал засвар	27,450,100.00	9,850,000.00	17,600,100.00	35.9
Томилолт, зочны зардал	3,500,000.00	3,258,288.00	241,712.00	93.1
Дотоод албан томилолт	3,500,000.00	3,258,288.00	241,712.00	93.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	381,152,500.00	246,498,464.53	134,654,035.47	64.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	381,152,500.00	246,498,464.53	134,654,035.47	64.7
Хөрөнгийн зардал	209,775,199,600.00	209,775,199,515.80	84.20	100.0
Дотоод эх үүсвэрээс	209,775,199,600.00	209,775,199,515.80	84.20	100.0
Барилга байгууламж	209,775,199,600.00	209,775,199,515.80	84.20	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	210,917,660,200.00	210,761,720,935.16	155,939,264.84	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,142,460,600.00	986,521,419.36	155,939,180.64	86.3
Улсын төсвөөс санхүүжих	1,142,460,600.00	986,521,419.36	155,939,180.64	86.3
Гадаадын эх үүсвэрээс	209,775,199,600.00	209,775,199,515.80	84.20	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
Ажиллагсад бүгд				
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.0
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгжийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн зохицуулагч Т.Болорчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн бүртгэлийг ангиллын дагуу зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Найдвар-Од аудит ХХК-ийн захирал Б.Алтанпүрэв, ахлах аудитор Ж.Энхчимэг, аудитор Б.Оюунчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01/21 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн зорилго нь цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг хоногт 250000 м3 болгож нэмэгдүүлж, ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг Монгол улсын MNS:4943-2015 стандартын түвшинд хүргэж цэвэршүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой ба цэвэрлэх байгууламжаас гарах усыг хэт ягаан туяаны UV төхөөрөмжөөр халдваргүйжүүлэн Туул голд нийлүүлэх, лагаас мезофил зарчмаар биохий гарган авах замаар эрчим хүч, дулаан гаргаж өөрийн үйлдвэрийн дотоод хэрэгцээний зардлыг нөхөж, улмаар эрчим хүч үйлдвэрлэдэг цэвэрлэх байгууламж болох эхлэлийг тавих явдал юм.

Монгол Улсын Засгийн газрын 2017 онд 311 тоот тогтоолоор “Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийг баталж БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох /1.0/ нэг тэрбум ам долларын зээлээс 262.7 сая ам.долларыг зарцуулан 17.6 га газрыг ашиглан барихаар төлөвлөж, үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн зорилго нь Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Монгол улсын стандартыг хангасан усыг байгальд нийлүүлэх, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төслийн санхүүжилтийн нийт өртөг нь 262.7 сая ам доллар бөгөөд үүнээс Монгол улс 5% буюу 13.1 сая ам долларын санхүүжилт хийнэ. Төслийн үндсэн хэрэгжүүлэгч байгууллага Барилга хот байгуулалтын яам, хамтран хэрэгжүүлэгч Сангийн яам болно. Төсөл хэрэгжүүлэх хугацаа 2019-2023 он.

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, “Сангийн сайдын 2015 оны 7-р сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалаар

батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 9.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн “Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн нэгжийг байгуулсан байна.

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл нь 2020 онд 5 зорилтод 24 арга хэмжээ төлөвлөснөөс 2 арга хэмжээ нь Ковид-19 өвчнөөс шалтгаалан хойшилсон бөгөөд бусад бүх ажлаа гүйцэтгэсэн байна.

1. Зураг төслийн ажлын хүрээнд цэвэрлэх байгууламжийн ажлын нарийвчилсан зураг төсөл гаргуулж Монгол хэл рүү хөрвүүлэн Монгол улсын барилгын норм, дүрэмд нийцүүлэн магадлалаар оруулж батлуулах ажил ажил хийгдсэн байна.
2. Барилга угсралтын ажлын хүрээнд усны чанар, технологийн судалгаа хийх, туслан гүйцэтгэгч компани сонгон шалгаруулах, бетон зуурмагийн үзелийн тохирлын гэрчилгээ болон тусгай зөвшөөрөл авах, цахилгаан дамжуулах агаарын шугамыг шилжүүлэх ажлыг шийдвэрлэх, барилгын талбайн орц гарцын ажил, хуучин хлорын станцад хадгалагдаж буй үлдэгдэл хлорыг устгах, гаднаас ажиллах хүч оруулж ирэх, гүйцэтгэлд нь хяналт тавих, цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажилд хяналт тавих, гадна инженерийн дэд бүтцийг эхлүүлэх зэрэг ажлууд төлөвлөгдөж хийгдсэн байна.
3. Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалтын ажлын хүрээнд тоног төхөөрөмжийн судалгаа захиалга хийгдэж эхний ээлжийн урьдчилгаа төлбөрүүд төлөгдсөн байна.
4. Сургалт томилолтын хүрээнд БНХАУ-ын цэвэрлэх байгууламжтай танилцах сургалт, Цэвэрлэх байгууламжийн модель боловсруулах программын сургалт, ерөнхий гүйцэтгэгч, зургийн компанитай уулзалт зохион байгуулахаар төлөвлөснөөс БНХАУ-ын цэвэрлэх байгууламжтай танилцах сургалт Ковид-19 өвчнөөс болж хойшилсон байна. Бусад ажлууд бүрэн хийгдсэн байна.
5. Санхүү, төлөвлөгөө, худалдан авалтын ажлын хүрээнд ТХН-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж шийдвэрлүүлэх, төслийн төлөвлөгөө тайлан мэдээ бэлтгэх, шилэн дансны удирдлагын мэдээллийн санд мэдээлэл оруулах, санхүү худалдан авах ажиллагааны хөрөнгө батлуулах, цэвэрлэх байгууламжийн модель боловсруулах программ худалдан авах (Ковид-19 өвчний улмаас хойшилсон), төслийн барилга байгууламжийн ажилд шаардлагатай БНХАУ-ын зарим стандарт, норм дүрмүүдийг орчуулж Монгол улсын стандартад нийцүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлуудыг төлөвлөж гүйцэтгэсэн

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд ямар нэг өөрчлөлт ороогүй.

3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,161,004.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,610.0 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгжийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 210,007,805.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	117.2	117.2
Урьдчилгаа	0.0	209,775,199.5	209,775,199.5
Бараа материал	35,257.2	50,530.1	15,272.9
Үндсэн хөрөнгө	175,418.3	392,634.1	217,215.7
Нийт хөрөнгийн дүн	210,675.5	210,218,480.9	210,007,805.4
Засгийн газрын хувь оролцоо	210,675.5	210,218,480.9	210,007,805.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	210,675.5	210,218,480.9	210,007,805.4

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 209,775,191.5 мянган төгрөгт хүрсэн нь гадаадын эх үүсвэрээс олгох орлогыг хүлээн авч, төслийн гэрээний дагуу 30.0 хувийн урьдчилгааг гүйцэтгэгчид олгосноос шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 50,530.1 мянган төгрөг болж 15,272.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилд инженер техникийн ажилчдад ажлын нормын хувцас худалдан авсан, мөн тайлант жилд НББ-ийн бодлогын баримт бичгийг 4,500.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж бараа материалд бүртгэсэн, шатахууны картанд 12,940.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 392,634.1 мянган төгрөг болж 217,215.7 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн сайдын багцад батлагдсан “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн Монголын талын хөрөнгө”-ийн эх үүсвэрээс санхүүжсэн 250,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг хүлээн авсан, 9,850.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 210,007,805.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төслийн 30 хувийн урьдчилгаа 209,775,199.5 мянган төгрөгийг олгож урьдчилж төлсөн зардалд бүртгэсэнтэй холбоотой байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 210,175,557.4 мянган төгрөгөөр буюу 213 дахин өссөн байна. Өсөлтийн гол шалтгаан төслийн урьдчилгаа орж ирсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 378,777,6 мянган төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, нийгмийн даатгал шимтгэлийн зардлууд өссөн нь төслийн нэгж нь тайлант онд батлагдсан орон тоогоор бүрэн ажиллаж эхэлснээс шалтгаалсан байна. Мөн төсөл хэрэгжүүлэх нэгж нь 2019 онд 5 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд тайлант онд бүтэн жилээр түрээсийн төлбөр төлснөөс шалтгаалан ажлын байрны түрээсийн төлбөр өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг болон нийт зардлыг 1,142,600.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн, Сангийн яам гадаадын эх үүсвэрээс төслийн гэрээний дагуу урьдчилгааг гүйцэтгэгчид олгосон 30.0 хувийн санхүүжилт 209,775,199.6 мянган төгрөгийн дүнгээр нэмэгдүүлэн 210,917,660.2 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,142,600.6 мянган төгрөг, Сангийн яам гадаадын эх үүсвэрээс төслийн гэрээний дагуу урьдчилгааг гүйцэтгэгчид 30.0 хувийн 209,775,199.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, нийт 210,917,660.2 мянган төгрөгийг эх үүсвэр бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 986,521.4 мянган төгрөг, төслийн барилга байгууламжийн урьдчилж төлсөн зардалд 209,775,199.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 156,839.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.9 хувь, үүнээс урсгал зардлын гүйцэтгэл 86,3.9 хувьтай байгаа нь тайлант жилд төлөвлөсөн шатахууны зардал, багаж хэрэгсэл худалдан авах болон бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлууд нь Ковид-19-тэй холбоотойгоор БНХАУ-аас төсөл дээр ажиллах мэргэжилтнүүд ирээгүй, үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн явуулаагүйтэй холбоотойгоор зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 33 мэдээллээс 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй гэх шалтгаанаар Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулаагүй нь журмын 3.2.1 заалтыг зөрчсөн.

Шилэн дансанд "Цахилгаан дамжуулах агаарын шугамын №24, №25, №26 завсрын тулгууруудыг өндөрлөгөөтэй анкер тулгуураар солих, трассыг зөөн шилжүүлэх ажлын зураг, төсөв боловсруулах ажил"-ын тендерийн үнэлгээний хорооны гэрээ байгуулах, хөрөнгө зарцуулах шийдвэр болон шууд гэрээ байгуулах аргаар худалдан авсан компьютер хэрэгслийг худалдан авах шийдвэрийг байршуулаагүй нь журмын 3.2.11-д заасан ".... хөрөнгө мөнгө зарцуулсан аливаа шийдвэрийг ... PDF форматаар" байршуулах заалтыг зөрчсөн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,056.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 75.0 хувьтай байна.

Шилэн дансны талаар өгсөн өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 250,800.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 250,800.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилтийн (дансны ангилал андуурсан) залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Сангийн сайдын багцад батлагдсан “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн Монголын талын хөрөнгө” төсөл арга хэмжээний эх үүсвэрээс санхүүжсэн автомашиныг үндсэн хөрөнгийн машин, тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн байсныг үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгсэл дансанд бүртгэж залруулга хийсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулаагүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 33 мэдээллээс 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Үүнд:

1. Төсвийн хэмнэлт хэтрэлтийн дүнг гаргасан боловч тэдгээрийн шалтгааныг тодорхой тайлбарлаагүй /журмын 3.2.2/;
2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, дүнг үнэн зөв мэдээлсэн боловч шийдвэрийн хуулбарыг байршуулаагүй /журмын 3.2.10/;
3. Төслийн нэгжийн ажилчдын болон суудлын автомашин нийлүүлэх тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн сонирхлын зөчилгүй тухай мэдэгдлийг байршуулсан боловч зураг төслийн тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг байршуулаагүй /журмын 3.2.18/ байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6-р зүйл Шилэн дансны мэдээллийг байгууллагын удирдлага тогтмол хугацаанд мэдээлнэ гэсэн заалтын 6.1.1 болон 6.1.2-р заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын залруулга болон албан шаардлага

Аудитаар илэрсэн 250,800.0 мянган төгрөгийн алдааг аудитаар залруулсан ба өмнөх оны хэрэгжүүлээгүй зөвлөмжид албан шаардлага хүргүүлэв.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл нь 2021 онд бүрэн хүчин чадлаараа ажиллах бөгөөд төслийн зарцуулалтын гүйцэтгэлийн тайлан бэлтгэж батлуулсны дараа санхүүжилтээ авах тул 2021 оны санхүүгийн тайланд хийх аудитаар төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлын зарцуулалтаас гадна барилгын ажлын бодит гүйцэтгэлд тусгайлсан горим гүйцэтгэх шаардлагатай гэж үзлээ.

Албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгжийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/54/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 33 мэдээллээс 3 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 болон 6 дугаар зүйлийг зөрчсөн, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.	-	Албан шаардлага өгөх	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	Т.Болорчулуун Х.Галсанхүү
ДҮН					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 189/А0170066

Улаанбаатар хот

СМ-2021/54/СТА-ТХМ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгжийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 33 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэл байршуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлж, биелэлтийг 2021 оны 6 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төслийн нэгжийн зохицуулагч Т.Болорчулуун, санхүүгийн ажилтан Х.Галсанхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

НАЙДВАР-ОД АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

О.БАЯРМАА

Б.АЛТАНПҮРЭВ

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for consistent letter formation. There is no text or other markings on the page.

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for consistent letter formation. There is no text or other markings on the page.